



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 42

Есөнбулаг сум

“Алтайн мянган харваач” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “Ж” заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Алтайн мянган харваач” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. “Алтайн мянган харваач” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жилийн эцэст ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
20... оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тогтоолын
хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ ҮНДЭСНИЙ СУРЫН ХАРВААНЫ СПОРТЫГ ЭРЧИМТЭЙ ХӨГЖҮҮЛЭХ «АЛТАЙН МЯНГАН ХАРВААЧ» ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг: Удиртгал

Эртний их Хүннү гүрний үеэс Монгол зон олон хүчит бөхөө барилдуулж, хүлэг морьдоо уралдуулж, сэц мэргээ сорин, ид чадлаа бататган ирсэн нь “Эрийн гурван наадам” хэмээн баялаг сайхан баяр ёслол болон зуун зуунд уламжлагдан хөгжсөөр өнөөг хүрчээ.

Өндөр сүрлэг Алтайдаа, өргөн уудам говь хөндийдөө эрх дураараа адуу малаа адгуулж, ан гөрөөгөө хийж, эх нутгаа, элгэн олноо атаат дайснаас өмгөөлөн хамгаалж явсан баатарлаг түүхт Алтайчууд бид бол Их Монгол гүрнийг бүтээн босгоход голлон оролцсон Жалайр, Бэсүд, Урианхай, Олхонуд зэрэг 26 овгийн ихэнхийн нь үр хойчис билээ. Хожмоо Халхын анхны гурван ханы нэг, хазайсан цагт нь Тэнгэрийн төрөө засах ерөөлтэй, эрэлхэг дайчин Үйзэн Засагт ханы гал голомтыг тулалцсан, өнөө ч бадраан тээж яваа ард түмэн юм.

Найман зууны тэртээ Хавт Хасарын хүү Есүнгэ мэргэн бээр 335 алд (500 гаруй метр газар) газарт байгаа алдалгүй мэргэн оносон давтагдашгүй амжилтыг Их хааны зарлигаар хас чулуунаа сийлэн үлдээж байжээ. Энэ нь зөвхөн мэргэн харвааны хөшөө дурсгал төдий биш, хойч үедээ бахархал, үлгэрлэл, урам зоригийг нь бадраасан уриа дуудлага байлаа.

Үндэсний сурын спорт нь хувь хүний бие бялдын болон хүмүүжлийн ихээхэн ач холбогдолтой спорт юм. Эрийн гурван наадмын нэг сур харваа нь зөвхөн эрхийний эрч, сумны шулууны хэрэг төдий биш харваач хүний ур ухаан, сэтгэлгээний чадавхи, хүч чадал, зориг тэвчээр, хурц хараа, ёс зүй, хийморь золбоог шингээсэн зан үйлийн бүхэн бүтэн цогц болон хөгжиж, өнөө цагт олон түмний бие бялдар, оюун санаа, хүмүүжлийн хөгжилд нэн чухал спорт болжээ.

Иймд сум орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, аж ахуй нэгж, хамт олон, хүүхэд бүр үндэсний сурын спортоор хичээллэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлж материаллаг баазыг бэхжүүлэх, сурын харваа сонирхогчдыг нэмэгдүүлэх, мэргэжлийн өндөр зэрэгтэй харваачид бэлтгэн гаргах зайлшгүй шаардлага урган гарч байна.

Эрт цагийн энэхүү дуудлагаар Алтай нутгийн атгандаа аатай, эрхийдээ эрчтэй, хараандаа ончтой хүүхэд залуус, ард иргэд харваанд олноороо сур шамдан суралцах болсон тул энэ спортыг улам өргөжүүлэн хөгжүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх, олон нийтийн дунд сурталчлах түгээх төдийгүй аймаг улсдаа алдар цугаа дуурсгасан өндөр мэргэшсэн харваачдийг төрүүлэн гаргах зүй ёсны шаардлага бий болжээ.

Говь-Алтай аймгаас Улсын мэргэн 2, Өсөх идэр мэргэн 1, Буриад сурын улсын мэргэн 1, Спортын мастер 32 Спортын дэд мастер 18 төрөн гарсан байдаг. Аймгийн үндэсний сурын холбоо 2015 онд байгуулагдсанаас хойш үйл ажиллагаагаа эрчимтэй явуулж, сурын спорт сонирхогчид хүүхэд залуучуудын дунд бэлтгэл, сургалт, наадмуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж, Спортын мастер 5, Дэд мастер 4-ийг төрүүлэн улмаар 2016 онд “Улсын шилдэг” холбоо, 2017 онд улсын “Шилдэгийн шилдэг” холбоогоор шалгарлаа.

Говь Алтай аймгийн харьяат Улсын цол хүртсэн тамирчид

Үзүүлэлт	Цол	
Улсын цол хүртсэн тамирчид	Дархан мэргэн	1
	Мэргэн	1
	Улсын гарамгай харваач	1
	Улсын гоц харваач	1
	Спортын мастер	32
	Спортын дэд мастер	18

Аймгийн цол хүртсэн тамирчид

Аймгийн цол хүртсэн тамирчид	Аймгийн мэргэн	34
	Аймгийн гарамгай харваач	31
	Аймгийн гоц харваач	41

Манай аймаг 2016 онд сурын харвааны талбайг шинээр байгуулж, 2017 онд “Багийн улсын аварга шалгаруулах тэмцээн”-ийг аймагтаа авч зохион байгуулан 25 багийнн 480 гаруй харваач оролцлоо.

2017 оны байдлаар аймгийн хэмжээнд 120 орчим харваачид хичээллэж байна. 2000 оноос эхлэн харьцуулахад:

Үзүүлэлт	2000	2005	2010	2014	2015	2016	2017	2018
Хичээллэгсдын тоо	34	31	23	38	43	56	89	118

Насанд хүрэгчид /эр/	4	4	10	17	24	36	69	96
Эмэгтэй	2	2	3	4	6	6	11	13
Хүүхэд	28	25	10	17	13	20	20	24

Эндээс харахад Алтай түмний бахархал, уламжлал болсон сурын харваагаар хичээллэгсдийг нэмэгдүүлэхэд залуу тамирчидыг бэлтгэх ажил хангалтгүй, хүн амын дунд үндэсний сурын спортыг хөгжүүлэхэд шаардагдах хэрэглэл материал дутмаг, сурын харвааны талаарх иргэдийн ойлголт хангалтгүй, орон нутагт үндэсний сурын үйлдвэрлэл байхгүй, мэргэжлийн дасгалжуулагч хүрэлцээгүй, сургалт сурталчилгааны ажил хийгддэггүйгээс сурын спортыг сонирхогч, хичээллэгсдийн тоо дорвитой нэмэгдэхгүй байна.

Иймээс цаашид Эрийн гурван наадмын нэг төрөл үндэсний сурын спортыг морин уралдаан, бөхийн барилдаантай эн чацуу хөгжлийн түвшинд хүргэх, сурын харвааны ач холбогдолыг иргэдэд сурталчилах, ёс жаяг, зан үйлийг зааж сургах, стандарт хэрэглэл материалыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, сургалт дасгалжуулалтыг сайжруулан, сонирхогч хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх зайлгшүй шаардлага байна.

Үндэсний сурын харвааг хөгжүүлэх Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор сум орон нутагт үндэсний сурын холбооны ажлын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлага зохион байгуултанд оруулах, хүүхэд залуучуудад сурын харвааны сургалтыг явуулж, арга барилыг өвлүүлэх, зааж сургах хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх, нум сумны үйлдвэрлэлийг дэмжих, орон нутагт Үндэсний сурын харвааг аймгийн хөтөлбөр хэрэгжих хугацаанд “Алтайн 1000 харваач”-тай болгон хөгжүүлэх нь энэ хөтөлбөр боловсруулах үндэслэл болсон.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго

Монголчуудын уламжлалт үндэсний сурын харвааг аймгийн хэмжээнд хөгжүүлж, 2020 он гэхэд улсын цолтой харваачид 5-аас доошгүйг төрүүлэн, 1000-аас доошгүй сурын харваачийг бэлтгэнэ.

2.1 Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1 Аймгийн хэмжээнд үндэсний сурын харвааг хөгжүүлэх удирдлага зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгоно.

2.1.2 Үндэсний уламжлалт сурын харвааг хүүхэд, залуу хойч үеийнхэнд зааж өвлүүлэн, түүгээр дамжуулан өв тэгш хүмүүжил төлөвшил олгох, олон нийтэд сурталчлах, уламжлалт зан заншлыг сэргээж, дэлгэрүүлэх, хичээллэгсдийн хүрээг өргөжүүлэн, мэргэжлийн ур чадвар бүхий өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэнэ.

2.1.3 Үндэсний сурын харвааг орчин үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан хөгжүүлж, нум сумны үйлвэрлэлийг дэмжин, сурын спорт хөгжүүлэх материаллаг орчинг бэхжүүлнэ.

Гурав: Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн

3.1 Аймгийн хэмжээнд үндэсний сурын харвааг хөгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

3.1.1 Сум тосгон бүрд үндэсний сурын харвааны товчоог шинээр байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, манлайлан үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний сурын товчооны ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх

3.1.2 Тамирчид, дасгалжуулагчид, дэмжигчид, ивээн тэтгэгчид, хандивлагчидтай хамтран ажиллах

3.1.3 Байгууллага, сургууль бүрт үндэсний сурын спортын клуб байгуулж, хүүхэд залуучуудыг өргөнөөр хамруулах

3.1.4 Сурын харвааг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор жил бүр үндэсний сурын товчооны ажлыг дүгнэж, сурталчлах, урамшуулах

Хүрэх үр дүн:

Сум бүрт үндэсний сурын харвааны товчоо, байгууллага, сургууль бүрт үндэсний сурын клуб байгуулагдах замаар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтад орсон байна.

3.2 Үндэсний уламжлалт сурын харвааг хүүхэд, залуу хойч үеийнхэнд зааж өвлүүлэн, түүгээр дамжуулан өв тэгш хүмүүжил төлөвшил олгох, олон нийтэд сурталчлах, уламжлалт зан заншлыг сэргээж, дэлгэрүүлэх, хичээллэгсдийн хүрээг өргөжүүлэн, мэргэжлийн ур чадвар бүхий өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэнэ.

3.2.1 Аймгийн бүх сургууль, хүүхдийн амралт, зусланд үндэсний сурын секц дугуйлан хичээллүүлж, клубууд байгуулан сонирхлыг бий болгосноор сурын

харваагаар хичээллэх хүүхдийн тоог нэмэгдүүлэх, хүмүүжил төлөвшил олгох

3.2.2 Ерөнхий боловсролын сургуулиудад үндэсний сурын харвааны ёс жаяг, дэгийн талаар сургалт сурталчилгааны ажлыг тогтмолжуулж, сурын харвааны уухайг өсвөр үеийхэнд сурган өвлүүлэх

3.2.3 Үндэсний сурын харвааны арга зүйч, багш дасгалжуулагч нарыг бэлтгэн мэдлэг боловсролыг дээшлүүлэх

3.2.4 Сурын харвааны шүүгчдийг бэлтгэх

3.2.5 Уламжлалт үндэсний халх, урианхай, буриад харвааны нэрэмжит тэмцээнүүдийг бий болгож зохион байгуулах

3.2.6 Говь-Алтай аймгийн харьяат улс, аймгийн өндөр цолтой ахмад харваачдыг алдаршуулах, хүндэтгэл үзүүлэх

3.2.7 Аймгийн төв музейд үндэсний сурын үзмэрийн булан байгуулах

3.2.8 Аймаг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үндэсний сурын спортыг хөгжүүлэх арга зүйн мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол хийх

3.2.9 Бүс, улс, олон улсын арга хэмжээг аймагтаа зохион байгуулж, үндэсний сурын спортыг сурталчлах

Хүрэх үр дүн:

Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж, эхлэн суралцагсадын тоо нэмэгдэн тэмцээнд оролцох тамирчдын ур чадвар дээшилсэн байна.ц

3.3 Үндэсний сурын харвааг орчин үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан хөгжүүлж, нум сумны үйлвэрлэлийг дэмжин, сурын спорт хөгжүүлэх материаллаг орчинг бэхжүүлэх

3.3.1 Сум бүрт үндэсний сурын талбайг байгуулах

3.3.2 Үндэсний сурын спортын тоног хэрэгсэл үйлдвэрлэх иргэд, аж ахуй нэгж байгууллагын санаачилгыг дэмжиж орон нутгийн үйлдвэрлэлийг бий болгох

3.3.3 Товчоо, клуб, сонирхогчдыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг үе шаттай хийх

3.3.4 Сургалтын нум сумыг орон нутагт худалдаалж, товчоо, клуб, сонирхогчдыг хангахад хямд үнийн бодлогыг хэрэгжүүлэх

3.3.5 Үндэсний сурын аймгийн төв талбайг өргөжүүлэн, тохижуулах

Хүрэх үр дүн

Үндэсний сурын спортын төрлүүд хөгжих нөхцөл, материаллаг орчин бий болсон байна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлана

4.1.1 Үндэсний сурын спортыг хөгжүүлэх үйл ажиллагаа нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамтын ажиллагаанд тулгуурлана

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.

5.1 Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, салбар дундын үйл ажиллагааг зохицуулан чиглүүлэх үүрэг бүхий аймгийн зөвлөлийг Засаг даргын захирамжаар байгуулна.

5.2 Хөтөлбөрийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сумын Засаг даргын захирамжаар байгуулна.

5.3 Аймаг, сумын зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх, оролцогч байгууллагуудын ажлын уялдаа, холбоог хангах, үр дүнг тооцох, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах асуудлыг хариуцан хэрэгжүүлнэ.

5.4 Үндэсний сурын харвааны холбоо нь товчоо, клубуудыг удирдан чиглүүлж, арга зүйгээр хангах, багш, дасгалжуулагч, шүүгчдийг бэлтгэнэ

5.5 Товчоо, клубууд нь аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж болон ажиллан хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэн анхан шатны мэдлэг, дадал чадварыг эзэмшүүлнэ.

5.6 Аймгийн хэмжээнд дасгалжуулагчид, шүүгчид, улсын цолтой харваачдын зөвлөлүүдийг тус бүр байгуулан ажиллуулна.

5.7 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: 2018-2020 он

Зургаа: Хөтөлбөрийн санхүүжилт

6.1.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

6.2.1 Улсын болон орон нутгийн төсөв, аймаг сумын орон нутгийн хөгжлийн

сан

6.2.2 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хандив, тусламж

6.2.3 Төсөл хөтөлбөр

6.2.4 Бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол соёл урлагийн газар, аймгийн үндэсний сурын холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

7.1.1 Шалгуур үзүүлэлт:

№	Үйл ажиллагаа	2017 он буюу суурь үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он
1	Үндэсний сурын харваагаар хичээлэгч насанд хүрэгч/эр/-ийн тоо	118	1000	1050	1150
2	Үндэсний сурын харваагаар хичээлэгч насанд хүрэгч/эм/-ийн тоо	11	300	350	380
3	Үндэсний сурын харваагаар хичээлэгч хүүхдүүдийн тоо	14	300	350	380
4	Сургалтын нум сумны тоо	60	400	1000	1000
5	Сургалтын талбайн тоо	2	19	19	19
6	Сумдад үйл ажиллагаа явуулж буй товчооны тоо	1	18	20	20
7	Үндэсний сурын харвааны клубтай сургуулийн тоо	0	29	35	40
8	Үндэсний сурын харвааны клубтай байгууллагын тоо	0	19	23	26
9	Үндэсний сурын харвааны сургагч багш, дасгалжуулагчийн тоо	1	30	50	70
10	Үндэсний сурын харвааны шүүгчийн тоо	0	25	40	50
11	Улсын цолтой үндэсний сурын харваачийн тоо	42	46	52	60
12	Аймгийн цолтой үндэсний сурын харваачийн тоо	41	44	48	54
13	Нум сумны үйлдвэрлэх	0	2	3	4

	хувийн хэвшлийн тоо				
14	Жилд зохион байгуулагдах тэмцээн, наадмын тоо	4	6	8	8

Найм. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

2018-2020 он

Ес. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгө

№	Шаардагдах зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал	Бүгд зардал	Санхүүжилтийн эх үүсвэр
1	Өөрөө сурах гарын авлага	1000 ш	3000	3 000 000	3.000.000	Үндэсний сурын холбоо
2	Сургалтын нум сум	760 ш	150000	114.000.000	150.000.000	Хувь хүн
		140 ш	150000	21.000.000		Боловсролын багцаас
		100 ш	150000	15.000.000		Байгууллага үйл ажиллагааны орлогоос
3	Сургагч багш, дасгалжуулагч бэлтгэх	60 хүнийг 2 удаа	4 хоног	7.200.000	7.200.000	АОНХС
4	Сумдад хүрч ажиллах, дадлагажуулах	12 хүн 6 удаа	20 хоног	7000.000	7000.000	АОНХС Үндэсний сурын холбоо
5	Тэмцээн наадмын зардал буюу ур чадвар шалгах ажлын зардал	90 удаа	200.000	18.000.000	18.000.000	АОНХС Үндэсний сурын холбоо
6	Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардал	30 удаа	100.000	3.000.000	3.000.000	АОНХС
7	Шүүгч бэлтгэх зардал	70 шүүгч	3 хоног	3.150.000	3.150.000	АОНХС
8	Улс, аймгийн цолтой ахмад харваачдыг алдаршуулах зардал	3 удаа	1000.000	3.000.000	3.000.000	Хандив
9	Аймаг, сумдад сурын талбай байгуулах	20 сум	2000.000	40.000.000	40.000.000	СОНХС
10	Бусад			5.000.000	5.000.000	АОНХС

239.350.000 төгрөг	Бүгд	зардал
---------------------------	-------------	---------------

Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилтийн эх үүсвэр /төг/
<p style="text-align: center;">Зорилт 1. Аймгийн хэмжээнд үндэсний сурын харвааг хөгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгоно.</p> <p style="text-align: center;"><u>Хүрэх үр дүн:</u> Сум бүрт үндэсний сурын харвааны товчоо, байгууллага, сургууль бүрт үндэсний сурын клуб байгуулагдах замаар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж, зохион байгуулалтад орсон байна.</p>					
1	Сум тосгон бүрд үндэсний сурын харвааны товчоог шинээр байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх	2018 онд	Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	-
2	Манлайлан үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний сурын товчооны ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх	2018-2020 он	АЗДТГ	Үндэсний сурын салбар холбоо	-
3	Дэмжигчид, ивээн тэтгэгчид, хандивлагчидтай хамтран ажиллах	2018-2020 он	Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	-
4	Байгууллага, бүрт үндэсний сурын спортын клуб байгуулж, ажилчдыг өргөнөөр хамруулах	2018 он	БТСГ Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	-
5	Сургууль бүрт үндэсний сурын спортын клуб байгуулж, хүүхэд залуучуудыг өргөнөөр хамруулах	2018 он	БСУГ, ГБХЗХГ Үндэсний сурын салбар холбоо	БТСГ, Сумын үндэсний сурын харвааны товчоо	-
6	Жил бүр үндэсний сурын товчоо, клубын ажлыг дүгнэж, сурталчлах, урамшуулах	2018-2020 он	АЗДТГ Үндэсний сурын салбар холбоо	БСУГ, ГБХЗХГ	АОНХС
<p style="text-align: center;">Зорилт 2. Үндэсний уламжлалт сурын харвааг хөгжүүлж, дэлгэрүүлэх,</p>					

хүүхэд залуу хойч үеийнхэнд сурын харвааны арга барилыг өвлүүлэх, зааж сургах, олон нийтэд сурталчлах, уламжлалт зан заншлыг сэргээж хичээллэгсдийн хүрээг өргөжүүлэн мэргэжлийн ур чадвар бүхий өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах

Хүрэх үр дүн:

Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж, эхлэн суралцагсадын тоо нэмэгдэн тэмцээнд оролцох тамирчдын ур чадвар дээшилсэн байна.

1	Аймгийн бүх сургууль, хүүхдийн амралт, ордон, зусланд үндэсний сурын секц дугуйлан хичээллүүлэх	2018-2020 он	БСУГ, ГБХЗХГ Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	-
2	Ерөнхий боловсролын сургуулиудад үндэсний сурын харвааны ёс жаяг, дэгийн талаар сургалт сурталчилгааны ажлыг тогтмолжуулж, сурын харвааны уухайг өсвөр үеийхэнд сурган өвлүүлэх	2018-2020 он	Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	
3	Үндэсний сурын харвааны арга зүйч, багш дасгалжуулагч нарыг бэлтгэн мэдлэг боловсролыг дээшлүүлэх	2018-2019 он	БТСГ, Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	АОНХС
4	Сурын харвааны шүүгчдийг бэлтгэх	2018-2019 он	БТСГ, Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	АОНХС
5	Уламжлалт үндэсний халх, урианхай, буриад харвааны нэрэмжит тэмцээнүүдийг бий болгож зохион байгуулах	2018-2020 он	Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	АОНХС Хандив
6	Говь-Алтай аймгийн харьяат улс, аймгийн өндөр цолтой ахмад харваачдыг алдаршуулах, хүндэтгэл үзүүлэх	2018-2020 он	АЗДТГ Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	Хандив
7	Аймгийн төв музейд үндэсний сурын үзмэрийн булан байгуулах	2019 он	Орон нутаг судлах музей	Үндэсний сурын салбар холбоо	УТ
8	1000 сурын харваачийн наадмыг Эрэн нуурт зохион байгуулах	2018 он	ИТХ, АЗДТГ Үндэсний сурын салбар	Сумын ЗДТГ Сумын үндэсний сурын харвааны товчоо	УТ АОНХС
9	Аймаг орон нутгийн хэвлэл,	2018-	АЗДТГ	Сумын	УТ

	мэдээллийн хэрэгслээр үндэсний сурын спортыг хөгжүүлэх арга зүйн мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол хийх	2019 он	Үндэсний сурын салбар холбоо	үндэсний сурын харвааны товчоо	
<p>Зорилт 3. Үндэсний сурын харвааг орчин үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан хөгжүүлж, нум сумны үйлвэрлэлийг дэмжин, сурын спорт хөгжүүлэх материаллаг орчинг бэхжүүлэх</p> <p>Хүрэх үр дүн <i>Үндэсний сурын спортын төрлүүд хөгжих нөхцөл, материаллаг орчин бий болсон байна.</i></p>					
1	Сум бүрт үндэсний сурын талбайг байгуулах	2018-2019 он	Сумын ЗДТГ Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	СОНХС
2	Үндэсний сурын спортын тоног хэрэгсэл үйлдвэрлэх иргэд, аж ахуй нэгж байгууллагын санаачилгыг дэмжиж орон нутгийн үйлдвэрлэлийг бий болгох	2018-2019 он	АЗДТГ Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	
3	Товчоо, клуб, сонирхогчдыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг үе шаттай хийх	2018-2020 он	Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	УТ Хандив
4	Сургалтын нум сумыг орон нутагт худалдаалж, товчоо, клуб, сонирхогчдыг хангахад хямд үнийн бодлогыг хэрэгжүүлэх	2018-2020 он	АЗДТГ Үндэсний сурын салбар холбоо	Сумын үндэсний сурын харвааны товчоо	
5	Үндэсний сурын аймгийн төв талбайг өргөжүүлэн, тохижуулах	2018-2020 он	АЗДТГ Үндэсний сурын салбар холбоо	БТСГ, Сумын үндэсний сурын харвааны товчоо	ОНТ